



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/10

Мандалговь

Өмч хамгаалах зөвлөл байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 1, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 6 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2.1, 2.2 үндэслэн ТУШААХ нь.

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт тавих үүрэг бүхий өмч хамгаалах зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Үйлчилгээний албаны дарга

Гишүүд:

Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан  
мэргэжилтэн

Мэдээллийн технологийн ажилтан

Нягтлан бодогч

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн  
хэлтсийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хариуцсан  
мэргэжилтэн


Хууль, эрх зүйн хэлтсийн Хууль тогтоомж,  
системчлэл, хүний эрх, гэмт хэргээс урьдчилан  
сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн

Хууль эрх зүйн хэлтэс, Архивын тасгийн дарга

Хоёр. Зөвлөл нь байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавихдаа хуулийн дагуу үйл ажиллагаа явуулах, Орон нутгийн өмчит хуулийн этгээд болон сумын өмч хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүний чиг үүргийг ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нь тусгахыг Өмч хамгаалах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/129 дүгээр тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



МОНГОЛЫН  
МАНДАЛГОВЬ

436210047